



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар

A/28

Онги

Сайн дурын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг түшиглэн орон нутагт объектын болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гал түймэрийг унтраах чиг үүргийг хэрэгжүүлэх гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Хэсгийн дарга: М.Мөнхбаатар (Найз багийн иргэн)

Гишүүд: З.Шинэхүү (Төгрөг багийн иргэн)

Д.Эрхэмбаяр (Онги багийн иргэн)

Б.Батболд (Найз багийн иргэн)

Д.Амартүвшин (Онги багийн иргэн)

М.Лувсандорж (Мааньт багийн иргэн)

2. Гал унтраах сайн дурийн хэсгийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг тогтоож бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн гал түймэр унтраах бүлгийн даргад, үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг онцгой комиссын орлогч дарга Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/38 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМАРСАНАА

